



## Агуулга

Бичил уурхай эрхлэгчдэд	2
Бичил уурхайн бүртгэгдээгүй нөхөрлөл (Нөхөрлөл)	4
1. Нөхөрлөлийн бүтэц зохион байгуулалт	4
Бичил уурхай гэж юу вэ?	4
Нөхөрлөл байгуулах	4
Нөхөрлөлийн гишүүд, харьяалал	5
Нөхөрлөлийн гишүүд хамтран ажиллах гэрээ бичгээр байгуулах	6
Нөхөрлөлийн дүрэм батлах	7
Даатгал, татвар төлөх	8
2. Нөхөрлөл олборлолт явуулахтай холбоотой техник технологи	11
Зөвшөөрөгдөх тоног төхөөрөмж	11
Аюулгүй ажиллагааны стандартууд	13
Химийн бодис болон тэслэх бодисийн хэрэглээ	16
Баяжуулах технологи	16
3. Нөхөрлөл бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах	19
Сумын Засаг даргатай гэрээ байгуулах	19
Гурвалсан болон олон талт гэрээ байгуулах	21
4. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	22
Аюулгүй ажиллагааны зааварчилгаа	22
Уул уурхайн аврах баг байгуулах	23
5. Байгаль орчны нөхөн сэргээлт хийх	24
Олборлолтын талбайн байгаль орчны ерөнхий байдлын үнэлгээ, зураг (өөрсдөө хийх)	24
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гаргах	25
Нөхөн сэргээлтийн дундын сан байгуулах	26
Ашиглалтын болон технологийн хаягдалаар бий болсон үүсмэл ордод нөхөн сэргээлт хийх (урьд нь эвдэгдсэн газар)	28
Эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд илрэлүүдэд нөхөн сэргээлт хийх (эвдэгдээгүй газар)	29
2. Бичил уурхайн Төрийн бус байгууллага (ТББ)	29
ТББ-ын зорилго	29
ТББ-ын нийтлэг үүрэг	31
ТББ-ын хариуцлага	32
Төрийн бус байгууллагын удирдах байгууллага	32
Удирдах зөвлөлийн хурал	34
ТББ-ын гишүүдэд тавигдах шаардлага	34
Санхүүжилт	34
Гишүүнчлэлтэй ТББ-ын онцлог	36
Туршлага, сургамж	37
3. Бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ын ирээдүйн чиг хандлага	41
Олон улсын туршлага	41
1. Бичил уурхайчдын эрх ашгийг хамгаалах үндэсний хэмжээний байгууллага	41
2. Шударга худалдаа, хариуцлагатай олборлолт (FTFM)	42

## Бичил уурхай эрхлэгчдэд

Хувираа алт олборлож буй хүмүүсээс «*Танай нутагт алт гарч байна уу*» гэж асуухад нэг хэсэг нь «*Гарч л байна, гэхдээ хөөж тугаад хэцүү юм...*», харин нөгөө хэсэг нь «*Энэ хэсэг хүмүүс ч газар шороог минь ёстой сүйдэлж байна даа*» гэж хариулах нь бий. Ашигт малтмал хувиараа олборлож буй иргэд өөрсдийн хамаатан садан, нутаг усныхнаа бараадан, хэсэг бүлгээрээ хамтран Доржийн бригадынхан, Завханы Тосонгийнхон гэх мэтээр нэрлэгдэх албан бус бүлгүүдийг үүсгэн ажиллаж заншсан байв. Тэдний буюу шинээр батлагдсан хуулийн нэр томъёогоор бол **бичил уурхай эрхлэгчдийн** хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны асуудал тодорхойгүй байсаар цөөнгүй жилийн нүүрийг үзэж, хуулийн нарийвчилсан зохицуулалт шаардагдаж байсан юм.

Харин “Ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орж, (2010 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн) “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” (Засгийн Газрын 2010 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 308 дугаар тогтоолоор)”, мөн “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” (АМГ-ын 2010 оны 4 сард) зэрэг хуульчилсан актууд батлагдан гарснаар бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа сайжирч, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах эрх зүйн орчин бүрдээд байна.

Бичил уурхай эрхлэгчид хуулийн дагуу **“бүртгэгдээгүй нөхөрлөл”**-ийн зохион байгуулалтанд орж, түүгээр ч зогсохгүй нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, орлогын татвараа төлж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага стандартыг мөрдөж ажиллах, байгаль орчны нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх үүрэг хүлээх боллоо. Эдгээр бүх шаардлага нь бичил уурхайчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн үйлчилгээг сайжруулахад чиглэгдэж байгаа бөгөөд бичил



уурхайчдын хариуцлагыг сайжруулж, ингэснээр олон нийтийн зүгээс илэрхийлдэг сөрөг үзэл бодол, байр суурийг багасгах боломж бүрдэнэ.

Мөн хөдөлмөр эрхлээгүй иргэдийг бичил уурхайгаар орлого олох, амьжиргаагаа сайжруулах боломжийг олгож байгаа нь ихээхэн ач холбогдолтой юм.

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн нэн тэргүүний зорилт бол зохион байгуулалтанд орж нэгдээгүй, үйл ажиллагаандаа баримтлах тодорхой дүрэм журамгүйгээр алт, жонш, нүүрс олборлож амьжиргаагаа залгуулж байгаа иргэдийг хуулийн дагуу нэгдсэн зохион байгуулалтанд орж ажиллах явдлыг дэмжихэд оршиж байна.

Энэхүү хялбаршуулсан гарын авлагаас та бүхэн хуулийн дагуу бичил уурхай эрхлэхийн тулд өөрийн эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагын талаарх холбогдох бүхий л мэдээллийг авах боломжтой юм.

## Бичил уурхайн бүртгэгдээгүй нөхөрлөл (Нөхөрлөл)

### 1. Нөхөрлөлийн бүтэц зохион байгуулалт

#### Бичил уурхай гэж юу вэ?

Бичил уурхай эрхэлж буй, эрхлэхийг зорьж буй хэн бүхэн нэн тэргүүнд бичил уурхайн талаарх хуулийн албан ёсны тодорхойлолтыг ойлгож мэдсэн байх нь чухал.

*“Ашигт малтмалын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь хэсэгт зааснаар «бичил уурхай» гэж Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг хэлдэг байна.*

Харин энэхүү үйл ажиллагааг хуулийн дагуу явуулахын тулд иргэд иргэдийн бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ажиллах үүрэгтэй юм.

#### Нөхөрлөл байгуулах

Ашигт малтмал, тухайлбал алт, жонш, нүүрс, ховор үнэт чулуу зэргийг бичил уурхайгаар хувиараа олборлох хүсэлтэй, эсвэл одоо олборлож буй иргэд “Ашигт малтмалын тухай хууль” (2010 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн нэмэлт өөрчлөлт бүхий), Засгийн Газрын 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу зохион байгуулалтанд орж ажиллах үүрэг хүлээнэ.

Хэрэв тухайн ашигт малтмал олборлож буй иргэн бичил уурхайгаар хувиараа олборлолт хийхгүй гэж үзээд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензтэй компанид ажиллахаар болбол Ашигт малтмалын (2006), Компанийн (1999), Хөдөлмөрийн тухай (1999) хуулийн холбогдох заалтууд болон Иргэний хуулийн (2002) 31,32 дугаар бүлэг дэхь **Ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах** гэрээний дагуу үйл ажиллагаа нь зохицуулагдана. Өөрөөр хэлбэл энэ гарын авлагад заасны дагуу үйл ажиллагаа





явуулахгүй гэсэн үг юм. Тэгэхээр лизензтэй компанид ажиллах боломжгүй, хөдөлмөр эрхлээгүй иргэд бичил уурхайд хувиараа олборлолт хийх нөхцөлд л бичил уурхайн дүрэм журмыг баримталж ажиллах үүрэг хүлээнэ.

Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1 дэхь хэсэгт заасны дагуу “бүртгэгдээгүй нөхөрлөл” байгуулсан иргэд л бичил уурхайн оргаар ашигт малтмал олборлох эрхтэй юм. Үг зүйлд: *«Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно»* гэж заасан байдаг.

Нөхөрлөлд гишүүнээр элсэх иргэдэд дараах үндсэн шаардлага тавигддаг. Үүнд:

Монгол Улсын иргэн байх;

18 нас хүрсэн байх;

Тухайн олборлолт явуулах орон нутгийн оршин суугч байх эсвэл оршин суугчаар бүртгүүлсэн байх;

Нөхөрлөлийн хамтран ажиллах дүрэм, гэрээг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурсан байх

Татвар, даатгалд хамрагдсан байх

Эдгээр үндсэн шаардлагаас гадна нөхөрлөлийн гишүүд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм болон нөхөн сэргээлт явуулах заавар зэргийг дагаж ажиллах үүрэгтэй.

### **Нөхөрлөлийн гишүүд, харъяалал**

Нөхөрлөлийн гишүүнээр 18 нас хүрсэн эрэгтэй, эмэгтэй ямар ч насны хүн элсэж болно. Энэ нь бичил уурхайд хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдлыг хориглож буй хэрэг юм. Мөн сэтгэцийн өвчтэй буюу иргэний эрх зүйн чадамжгүй иргэн болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах чадваргүй, хүнд өвчтэй хүн бичил уурхайн нөхөрлөлд элсэж олборлолт явуулж болохгүй.

Тухайн нөхөрлөл нь сум, дүүргийнхээ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр олгогдохоор зөвшөөрсөн газраас бусад газарт олборлолт явуулахыг хориглоно.

Орон нутагт бүртгэлтэй ажилгүй иргэд, малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд нөхөрлөлд элсэн орж болно. Харин төрийн албан хаагч болон уул уурхайн компанийн ажилтан нөхөрлөлд элсэн орж олборлолт явуулж болохгүй.

Гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүс, найз нөхөд нөхөрлөлд нэгдэж, хамтран ажиллахыг журмын дагуу хориглоогүй. Харин нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөлийн гишүүнээр давхар элсэж болохгүй бөгөөд энэ нь засгийн газрын 308-р тогтоолын дагуу уг нөхөрлөлд газар олгохоос татгалзах, гэрээ байгуулахгүй байх нэг үндэслэл болно.

### **Нөхөрлөлийн гишүүд хамтран ажиллах гэрээ бичгээр байгуулах**

Иргэдийн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх нь нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулсан тохиолдолд л үүсэх бөгөөд бусад хэлбэрийн зохион байгуулалтаар бичил уурхай эрхлэхийг хориглодог. Өмнө дурдсанчлан бичил уурхайг зөвхөн бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон иргэд л эрхэлж болохыг хуульчлан тогтоосон байдаг.

Тиймээс бичил уурхай эрхлэхийг хүссэн иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулах ёстой. Мөн хамтын ажиллагааны гэрээг нэг жилээр байгуулах бөгөөд гэрээнээс гарах нөхцлийг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

Хамтран ажиллах гэрээг нөхөрлөлд орж ажиллах бүх иргэд хамтарч байгуулах бөгөөд гишүүн бүрт гэрээний нэг хувийг хадгалуулна. Гэрээгээр нөхөрлөлийн гишүүд ашиг олохын тулд өөрсдөөсөө хураамж, тодорхой хэмжээний хөрөнгө эсвэл хөдөлмөрөө хоршиж үйл ажиллагаа явуулж олсон ашгаа хэрхэн захиран зарцуулах, хуваах зэрэг харилцааг зохицуулдаг. Энэхүү гэрээг хэрхэн байгуулахыг Иргэний хуулийн 476 - 482 дугаар зүйлээр зохицуулсан байдаг бөгөөд хамтран ажиллах гэрээнд дараах зүйлийг заавал тусгасан байна:

Гэрээний талуудын нэр, хаяг (бүтэн нэр, хаяг, иргэний үнэмлэхний хуулбар дагалдах)

Хамтын үйл ажиллагааны чиглэл, зорилго (ямар төрлийн ашигт малтмал бичил уурхайгаар олборлох, орлого нэмэгдүүлэх, нөхөн сэргээлт хийх, аюулгүй ажиллагааг хэрхэн мөрдөж ажиллах)



Талуудын эрх үүрэг (гишүүдийн үүрэг, хяналт тавих эрх, хүлээх хариуцлага, татвар даатгал төлөх)

Удирдлагын бүтэц, эрх, үүрэг (бүх гишүүдийн хурал, хурлын ирц, нөхөрлөлийн ахлагч сонгох, дундын хөрөнгийг зарцуулах эрх бүхий төлөөлөгч сонгох, хяналт тавих)

Ашиг, алдагдлыг хуваарилах журам (оролцогчдын хураамж, оруулах хувь, ашиг хуваарилах, оруулсан хөрөнгөд хувь тэнцүүлэн ашиг хуваарилах эсвэл хэлцлийн дагуу хуваах, алдагдал хуваах)

Гэрээнээс гарах журам (өөрөө гарах, гэрээ зөрчсөн талуудыг гаргах, гарахад дундын хөрөнгөөс хэрхэн хуваарилах, биелүүлээгүй хэлцлийг хэрхэн зохицуулах)

Гэрээний хугацаа (гэрээ байгуулсан огноо, гэрээ хүчинтэй байх хугацаа, гэрээ байгуулсан газар)

Гэрээг дуусгавар болгох үндэслэл, дундын эд хөрөнгийг хуваарилах журам (хугацаа дуусах, талууд хуралдаж шийдвэрлэсэн, талуудын дундын хөрөнгө дампуурлын төлбөрт олгогдсон, оролцогч талуудын хэн нэг нь нас барсан гэх мэт, үлдэх хөрөнгийг бүртгэж хуваарилах, гэрээ дуусгавар болох үед хүлээгдэж буй үүргийг өөрт ноогдох хэсэгт хувь тэнцүүлэн гүйцэтгэх зэргийг тусгаж өгнө)

Нөхөрлөл байгуулах иргэд өөрсдийн хүсэл сонирхолоор гэрээг байгуулах бөгөөд хэн нэг хүний шахалтаар уг гэрээнд нэгдэн орохыг хориглоно. Мөн оруулсан хөрөнгөөрөө аль нэг тал нь давуу эрх эдлэж болох бөгөөд үүнийг гэрээнд тусгаж өгнө. Хэрэв нөхөрлөлийн гишүүд санал нэгдвэл өөрсдийн гэрээнд хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх заалт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх шаардлагатай болно.

### **Нөхөрлөлийн дүрэм батлах**

Хамтран ажиллах гэрээнээс гадна тухайн нөхөрлөл үйл ажиллагаандаа баримтлах дүрмийг уг нөхөрлөлийг байгуулж буй иргэд зөвшөөрч баталсан байна. Уг дүрэмд “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” (АМГ 2011 оны 4 сард баталсан) болон “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар”-ыг гишүүд өөрсдийн үйл ажиллагаандаа өдөр тутамдаа хэрхэн дагаж мөрдөхийг заавал тусгасан байна.

Түүнчлэн нөхөрлөлийн гишүүд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон ажлын цаг, өдөр тутмын ажилдаа мөрдөж ажиллах шаардлага, татвар, даатгал зэргийг хэзээ, хэрхэн төлөх, дундын хөрөнгийн санг хөтөлж явуулах асуудал зэрэг бүх гишүүдийн дагаж мөрдвөл зохих үүргүүдийг голчлон тусгах ёстой. Мөн гишүүд хоорондын харилцаа, бүх гишүүдийн хурлыг хэрхэн зохион байгуулах, ахлагч болон дундын санг хөтөлж явах төлөөлөгч нарыг хэрхэн сонгох, солих зэрэг удирдлага зохион байгуулалтын шинжтэй зүйлсийг дүрмэндээ тусгана.

Ажлын байр, суурьшлийн бүс зэрэгт мөрдөх шаардлагыг мөн тусгаж өгөх нь зүйтэй. Тухайлбал ажлын байр болон суурьшлийн бүсэд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар ажиллахгүй байх, гишүүн бус хүнийг ажиллуулахыг хориглох, тоног төхөөрөмж, ажлын багаж техник болон түүний засвар үйлчилгээг хэн хариуцах, мөн химийн хорт болон аюултай бодис ашиглахгүй байх, тэсэлгээг хэрхэн гүйцэтгүүлэх зэргийг зааж өгсөн байна.

### **Даатгал, татвар төлөх**

Монгол Улсын хуулийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг тогтмол төлснөөр хуульд заасан хугацаа болоход тухайн бичил уурхайчинд өндөр насны тэтгэвэр болон эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх үүсэх төдийгүй үйлдвэрлэлийн осолд өртөх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг болзошгүй эрсдэл учирсан үед тэтгэмж авах боломж бий болох юм.

Бичил уурхай эрхлэгчдийн заавал мөрдвөл зохих, түүнчлэн тухайн нөхөрлөлд бичил уурхайгаар олборлолт явуулах газар олгох эсвэл гурвалсан гэрээ байгуулах нэг нөхцөл нь орлогын татвар болон даатгалыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөх явдал юм. Нөхөрлөл байгуулагдаж бичил уурхайгаар олборлолт явуулах “газар” хүссэн өргөдөл өгөхдөө нөхөрлөлийн гишүүдийн татварын дэвтэр, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрийн хуулбарыг хавсаргах ёстой. Эдгээрийн бүрдүүлэлт дутуу байх нь Сумын Засаг дарга эсвэл гурвалсан гэрээ байгуулах нөгөө талууд гэрээ хийхээс татгалзах шууд үндэслэл болно.

Заавал хамрагдах ёстой даатгал, татвар нь:

Нийгмийн даатгал

Эрүүл мэндийн даатгал

Хүн амын орлогын албан татвар



**Нийгмийн даатгалд** хамрагдахын тулд сумын нийгмийн даатгалын байцаагчтай уулзаж сайн дурын даатгалын гэрээ хийнэ. Даатгалын гэрээндээ өөрийн тодорхойлсон орлогын даатгалын шимтгэлээ сараар, улирлаар, эсвэл жилээр төлөх эсэхээ тохиролцож тусгаж өгнө. Үүний тулд:

Иргэний үнэмлэх,

ЗХ4 хэмжээтэй нэг хувь цээж зураг,

Хэрэв байгаа бол даатгалын дэвтэр: 1995 оноос өмнөх хөдөлмөрийн дэвтэр (хэрэв байгаа бол), 1995 оноос хойших нийгмийн даатгалын дэвтэр (хэрэв байгаа бол)

Даатгалын дэвтэр байхгүй бол, шинээр нээх, даатгалын дэвтрийн хураамж болох 1,000 төгрөгийг тухайн Сумын нийгмийн даатгалын санд тушаасан баримт

Даатгалын шимтгэлээ доорх тооцооллын дагуу эхний сарын төлбөрийг тухайн сумын нийгмийн даатгалын санд тушаасан баримтыг авч очно.

Даатгалд хамрагдахын тулд өөрийн орлогоо тодорхойлж уг орлогын 12%-ыг дараах байдлаар даатгана.

Тэтгэвэрийн даатгал 10% (арван хувь)

Даатгуулсан тохиолдолд:

өндөр насны тэтгэвэр;

тахир дутуугийн тэтгэвэр;

тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрх;

Тэтгэмжийн даатгал 1% (нэг хувь)

Даатгуулсан тохиолдолд:

хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

оршуулгын тэтгэмж;

жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх;

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 1% (нэг хувь)

Даатгуулсан тохиолдолд:

тахир дутуугийн тэтгэвэр;

тэжээгчээ алдсаны тэтгэвэр;

хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрх тус тус үүснэ.

Сайн дураар даатгуулагч нь өөрийн орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140,400 төгрөгөөр буюу (Хөдөлмөр,

нийгмийн зөвшилцлийн гурван талт Хорооны хурлын №1 шийдвэр, 2011 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн) хамгийн бага орлогоор тодорхойлж болох бөгөөд дээд хэмжээ нь үүнийг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэнэ. Тухайлбал хамгийн бага орлого буюу сард 140,400 төгрөгийн орлоготой гэж үзвэл 16,848 төгрөгийг сар бүр төлнө.

**Эрүүл мэндийн даатгалд** Монгол Улсын иргэн болон ажил хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд бүгд хамрагдах ёстой байдаг. Хуульд зааснаар эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар даатгуулагч иргэн жилд дээд тал нь 1,112,000 төгрөгтэй тэнцэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхтэй болдог байна. Эрүүл мэндийн даатгал төлсөн тохиолдолд сумын болон өрхийн эмнэлгээр даатгуулагчийн үйлчилгээг төсвөөс санхүүжүүлдэг бол аймаг, дүүргийн эмнэлэгт даатгуулагч зөвхөн 10%-ийг өөрөөсөө, улсын чанартай эмнэлэгт үзүүлсэн бол даатгуулагч 15%-ийг л төлнө. Харин даатгалгүй иргэд өөрсдөө бүх зардалаа хариуцна.

Хэрэв та өмнө нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байсан бол эрүүл мэндийн даатгалын дэвтрээ авч сумын нийгмийн даатгалын байцаагч дээр очиж үргэлжлүүлэн төлж болно. Хэрэв танд эрүүл мэндийн даатгалын дэвтр байхгүй бол:

Иргэний үнэмлэх

ЗХ4 хэмжээний нэг хувь зураг

Даатгалын дэвтр байхгүй бол 500 төгрөгийг тухайн сумын эрүүл мэндийн даатгалын санд тушаасан баримт (хаяж үрэгдүүлсэн бол зарлуулж, шинэ дэвтр авахын тулд 3,000 төгрөг төлнө)

Жилийн даатгалын шимтгэлээ сумын эрүүл мэндийн даатгалын санд тушаасан баримтаа авч очно.

Эрүүл мэндийн даатгалд нөхөрлөлийн гишүүд заавал хамрагдах ёстой бөгөөд хэрэв улсын төсвөөс нийгмийн даатгал нь төлөгддөг бол эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлагагүй. Малчин эсвэл оюутны хувьд сар бүрийн 670 төгрөг (2010-12-29-ны ЗГ-ын 346 дугаар тогтоолоор) буюу жилийн 8,040 төгрөг тушаадаг бол мөн давхардаж төлөх шаардлагагүй. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хувьд эрүүл мэндийн даатгал төлөх бол орлогын 1% -иар даатгуулах шаардлагатай болно. Энэ нь орлогоо 140,400 төгрөг гэж тооцвол сарын 1,404 төгрөг буюу жилийн 16,848 төгрөг тушаах болно.



**Орлогын албан татварыг** бичил уурхай эрхэлж буй нөхөрлөлийн гишүүд бүгд төлөх ёстой бөгөөд төлөх шимтгэлийг “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.16 –д заасны дагуу **53,000 төгрөгийн татварыг бичил уурхай ЭРХЭЛСЭН сар тутамдаа** төлөх ёстой. Бичил уурхай эрхлэгч иргэн тухайн сумын татварын албанд очиж бүртгүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

Иргэний үнэмлэх

ЗХ4 хэмжээний нэг хувь зураг

Гэрчилгээний үнэ 1,000 төгрөг татварын дансанд тушаасан баримт

Орлогын албан татварын дэвтэр авч татвараа тухайн ажилласан хоногоороо эсвэл сараар төлж болохоос гадна татварын байцаагчид бичил уурхай эрхэлж буй иргэд дээр очиж шууд хурааж, татвар хураасан баримт олгож болдог.

Ингээд эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, орлогын албан татварыг бодож сар бүр нэг бичил уурхайчин төлөх шимтгэлийг тооцвол:

Нийгмийн даатгалд 16,848 төгрөг (нийгмийн даатгалын гэрээндээ сарын орлогоо 140,400 төгрөгөөр бодсон тохиолдолд)

Эрүүл мэндийн даатгалд 670 төгрөг (сарын орлого 140,400 төгрөгийн 1%-иар тооцвол 1,404 төгрөг)

Орлогын албан татвар 53,000 төгрөг

Нийт 70,518 төгрөг тушаах болж байна. Хэрэв эрүүл мэндийн даатгалаа 1% -иар тооцвол энэ нь 71,252 төгрөг болно.

## **2. Нөхөрлөл олборлолт явуулахтай холбоотой техник технологи**

### **Зөвшөөрөгдөх тоног төхөөрөмж**

Бичил уурхайн үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасан, уурхайд ажиллахад тохирсон хориг түгжээтэй, хаалт хамгаалалт бүхий, шаардлага хангасан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглана. Олборлолтын нүхнээс уурхайчид болон хүдрийг татаж гаргахад хэргэлдэг гар татлага (*тайл мөн леботка*) гэхэд л түгжээтэй, шууд хөвөрч унахаас сэргийлсэн байх жишээтэй. Хэрэглэх олс, тросс зэрэг нь чанарын шаардлага хангасан сэмэрч муудаагүй, үжрээгүй байхыг анхаарах нь зүйтэй.



**1. Гар татлага болон олсны аюулгүй байдлын шалгалт, сургалт, Жаргалант, Баянхонгор, 2010**

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох, баяжуулахад химийн хорт болон аюултай бодис хэрэглэхийг хориглодог. Хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуулинд заасан байдаг.



**2. Усны шахуурга (помп)**



**3. Агаарын үлээгч (Компрессор)**

Мөн тэсэлгээг бичил уурхайчид өөрсдөө хийж болохгүй бөгөөд зөвхөн мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. Тиймээс гүний уурхайд бичил уурхайчид өөрсдөө тэсэлгээ хийх, тэсэлгээний бодис хадгалах зэрэг нь хуулиар хориотой зүйл юм.





Ашигт малтмал олборлоход хэрэглэгддэг гар татлага буюу тайл, компрессор эсвэл ус татах, зайлуулахад ашигладаг хүчин чадал багатай помп, даралтат өрөм, агааржуулагч, гэрэл зэрэг багаж тоног төхөөрөмж нь найдвартай ажиллагаатай байх, мөн гар багаж болох сков буюу хоёр талдаа иртэй нарийн төмөр, гурвалжин иртэй зээтүү зэрэг нь бүрэн бүтэн, олс буюу оосор зэрэг нь үжирч муудаагүй, ашиглах боломжтой байх хэрэгтэй.

Бичил уурхайн үйл ажиллагаанд ашиглах дотоод шаталтат хөдөлгүүрийн багтаамжийг  $500 \text{ см}^3$  –ээр хязгаарласан байдаг. Өөрөөр хэлбэл үүнээс илүү хүчин чадалтай хөдөлгүүр ашиглаж ажиллах тохиолдолд тухайн бичил уурхайчдыг зохион байгуулалтын өөр хэлбэрт орохыг шаардах болно.

Олборлолтыг хэмжээг нэмэгдүүлэхийн тулд өндөр хүчин чадалтай техник тоног төхөөрөмж ашиглах нь бичил уурхайчдаас илүү хариуцлага, үр чадвар шаардах учир бичил уурхайчид дээрх тохиолдолд хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч компанийн зохион байгуулалтанд орж ажиллах нь зүйтэй. Бичил уурхай эрхлэгчдээс жижиг, дунд хэмжээний уул уурхайн компани үүсэн бий болж цаашид тусгай зөвшөөрөл авч ажиллах нь боломжгүй зүйл биш юм.

Газрын гүнд ажиллаж буй бичил уурхайчид хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс уурхайн гүнээс ялгарах хорт болон шатамхай хийнээс сэргийлсэн үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг өмсөх ёстой. Мөн дэлбэрэлт үүсгэх, угаартах зэргээс сэргийлэхийн тулд газрын гүнд дотоод шаталтат хөдөлгүүр ажиллуулахыг хориглодог. Түүнчлэн цахилгаанаар ажилладаг багаж хэрэгслийн цахилгааны утас зэрэг нь хамгаалалтын бүрээстэй байх, гүнээс ялгарах хийнд оч хаяхааргүй байх ёстой юм.

$500 \text{ см}^3$  багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмж гэдэгт жижиг оврын компрессор, цахилгаан мотор, усны шахуурга зэрэг зүйлс орох бөгөөд энэ нь хүчин чадлын хувьд тийм ч бага биш юм. Ялангуяа БНХАУ-д үйлдвэрлэсэн дээрх багтаамж бүхий тоног төхөөрөмжүүд чадлын хувьд гологдохооргүй бөгөөд үнэ хямд байдаг.

### **Аюулгүй ажиллагааны стандартууд**

Аюулгүй ажиллагааны стандартыг “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д тусгасан байдаг бөгөөд бичил уурхайчид дагаж мөрдөх үүрэгтэй.

Бичил уурхайн ил уурхай болон бичил далд уурхайд өөр өөр стандартууд мөрдөгддөг. Тухайлбал, бичил уурхайд тавигдах шаардлагуудыг дараах байдлаар тодорхойлсон байна:

### **Бичил ил уурхайн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага**

- ⇒ Бичил ил уурхайд хэт өндөр, огцом босоо мөрөгцөг (хажуу хана) гаргахыг хориглох бөгөөд ашиглалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын хэд хэдэн догол гаргаж ашиглалт явуулна.
- ⇒ Мөрөгцөгийн өндөр нь чулуулгийн шинж чанар, оршиц, тогтцын байдлаас хамааран 2.5 м-ээс илүүгүй байна.
- ⇒ Ажлын мөрөгцөгийн налуугийн өнцөг нь зөөлөн тогтвортой чулуулагт 50 градусаас ихгүй, хадархаг чулуулагт 80 градусаас ихгүй байна.
- ⇒ Олборлолтын талбайн өргөн нь хүн, техник ажиллахад чөлөөтэй, аюулгүй байдлыг хангасан байх ба 2 м-ээс багагүй байна.
- ⇒ Ажлын мөрөгцөгт саравч гаргаж уяхыг хориглоно.
- ⇒ Дээд, доод доголууд дахь ажлын мөрөгцгүүд нэг босоо шугам дээр давхцаж болохгүй.
- ⇒ Уурхайн нэг доголоос нөгөөд шилжихэд 0.8 м-ээс багагүй өргөнтэй бат бөх шат ашиглах эсвэл 45 градусаас ихгүй налуутай гарц гаргасан байна.
- ⇒ Уурхайн ашиглагдсан хоосон орон зайг буцааж булах, хашаа босгох, анхааруулах тэмдэг тавих замаар аюулгүй болгоно.

Мөн бичил уурхайн далд уурхайд дараах шаардлагуудыг мөрдөж ажиллахаар дүрэмчилсэн байдаг. Ашиглах гэж байгаа ордын шинж чанар, байрлал, чулуулгийн хатуулгаас хамааран бичил далд уурхайд босоо, налуу, хэвтээ ам гаргана. Уурхайн амыг гаргахдаа аль болох бат бөх, ан цавгүй, хатуу чулуулагтай, нуралт, гулсалт үүсэхээргүй, хөрсний болон үерийн ус орохооргүй газрыг сонгоно.

### Бичил далд уурхайн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

- ⇒ Уурхайгаас ажилтнуудыг гаргахад зориулсан, ашигт малтмалын биед хүрч хоорондоо холбогдсон хоёроос доошгүй гарц гаргасны дараа олборлолт явуулна. Уурхайгаас газрын гадаргуу дээр гарах нэг амтайгаар олборлолт явуулахыг хориглоно.
- ⇒ Уурхайн аманд нуралт, гулсалтаас хамгаалсан бэхэлгээ хийнэ. Бэхэлгээг шуудайлж савласан элс, шороо, чулуу, мод, бетоноор хийнэ.
- ⇒ Уурхайн налуу амны налуугийн өнцөг нь тогтвортой хатуу чулуулагтай газарт 45 градусаас, хатуулаг багатай буюу тогтворгүй чулуулагтай газарт бол 10 градусаас илүүгүй байна.
- ⇒ Уурхайн босоо 2 амны хоорондын зай 10 м-ээс багагүй байна.
- ⇒ Уурхайн босоо, налуу амсрыг зориулалтын материалаар хашиж бэхлэх ба амьг тойрсон хамгаалалт хүрээ хийж **“Аюултай”** гэсэн үг бүхий анхааруулах тэмдэг тавина.
- ⇒ Уурхайн малталтын өндөр нь 1.5 м, өргөн нь 1.2 м-ээс багагүй байна.
- ⇒ Уурхайн малталтаар ажилтан явахад зориулсан хэсгийн налуу нь 15 градусаас ихгүй байх ба үүнээс их бол бэхлэгэнд бариул, гишгүүр, шат зэргийг хөдөлгөөнгүй бэхлэн тоноглоно.
- ⇒ Бичил далд уурхайн гүн нь 5 м ба түүнээс их байвал дамарт өргүүр ашиглана. Газар доор хүмүүс ажиллаж байгаа үед дамарт өргүүрийг ажиллуулах хүнгүй орхих, түгжээгүй дамарт өргүүр ашиглахыг хориглоно.
- ⇒ Уурхайн гүнд цэвдэг, тогтвортой хатуу чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ ба налуу малталтыг бэхлэхгүй байж болох бөгөөд нурал үүсэхүйц хэт их орон зай гаргаж малтахыг хориглоно.
- ⇒ Уурхайн гүнд хатуулаг багатай, тогтворгүй чулуулаг дундуур нэвтэрсэн хэвтээ ба налуу малталтыг дараах байдлаар бэхэлнэ:
  - Хүдрийн биет, хоосон чулуулгаар багана үүсгэж үлдээх;
  - Мод, төмрөөр тулгуур, багана босгох;
  - Элс, шороог шуудайд савлаж өрсөн багана босгох;
  - Мод, төмөр рама зангидаж чулуугаар дүүргэсэн багана босгох;
  - Малталтаа бүхэлд нь мод, төмрөөр бэхлэх.

- ⇒ Уурхайн малталтын аюулгүй байдлыг ажлын явцад, тэсэлгээний ажлын (мэргэжлийн компаниар) дараа шалгаж аюултай байдал илэрвэл ажлын ахлагч нарт яаралтай мэдэгдэж уг аюулыг яаралтай арилгах арга хэмжээ авна.
- ⇒ Ашиглахгүй болсон, цаашид хүндрэл бэрхшээл учруулж болзошгүй далд малталтыг устгаж аюулгүй болгох арга хэмжээ авна.
- ⇒ Уурхайн гүний малталт 10 м-ээс үрт байвал байгалийн болон зохиомол агааржуулалтын систем ашиглана.
- ⇒ Байгалийн агааржуулалтыг зөв хийхийн тулд уурхайн амууд газрын гадаргуу дээр 2 өөр түвшинд байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангах боломжгүй бол энгийн хоолой (яндан) гаргаж агааржуулна.
- ⇒ Уурхайн малталтын нийт үрт нь 20 м, түүнээс их байвал зохиомол агааржуулалт хийнэ. Зохиомол агааржуулалтанд сэнс ашиглана. Агаар дамжуулахад агаар нэвтрүүлдэггүй гялгар материалаар хийсэн хоолой ашиглана.

Эдгээр шаардлагуудыг дагаж мөрдөж ажилласнаар бичил уурхайн болзошгүй аюул ослын эрсдэлийг бууруулах юм. Түүнчлэн “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Хүдрийн ба, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”- ийг мөрдөж ажиллана.

### **Химийн бодис болон тэслэх бодисийн хэрэглээ**

Өмнө дурдсанчлан аль ч бичил уурхайд химийн хорт болон аюултай бодис хэрэглэхийг хатуу хориглоно. Мөн тэслэх бодисийг тусгай зөвшөөрөл бүхий, мэргэжлийн аж ахуйн нэгж, компаниар гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд бичил уурхайд хэрэглэхийг хатуу хориглодог.

### **Баяжуулах технологи**

Баяжуулах технологи нь алт олборлолт дээр илүү яригддаг. Бичил ил уурхайгаар олборлосон алтны агуулга бүхий шороог хуурай болон нойтон аргаар баяжуулж авч байгаа бөгөөд гол нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг илүү сайн анхаарах хэрэгтэй. “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар”-ыг нарийвчлан судалж, нойтон буюу хүндийн хүчний (гравитацийн) аргаар баяжуулахдаа урсгал усыг ашиглахгүй байх, баяжуулалтанд ашиглаж бохирдсон усыг хиймэл цөөрөм хэлбэрээр хурааж, тунгаасны дараа буцааж

усанд нийлүүлж хэвших шаардлагатай. Мөн алтны агууламжгүй шороо (зарим газар набор ч гэдэг), хаягдал шороо болон алтыг нь угааж авсан шороо буюу шламаа тусд нь хураах зэрэг зүйлийг эхнээс нь хэвшүүлэх шаардлагатай.



**4. Нойтон аргаар баяжуулж байгаа нь. Баянхонгор, Жаргалант, 2009**

Шороон ордны бичил уурхайгаар олборлосон алтны агууламж бүхий материалыг нойтон баяжуулалтын аргаар баяжуулахад төрөл бүрийн хориг бүхий дэвсгэрээр бүрсэн шлюзийг өргөн ашигладаг. Ингэхдээ шлюзний налуугийн хэмжээ, бүлинг дахь ус болон хатуу материалын харьцаа зэргийг тухайн ордын хүдрийн болон алтны ширхэгийн шинж чанараас хамаарч нарийвчлан тогтоох нь чухал юм.



**5. Хуурай аргаар баяжуулж байгаа нь.  
Баянхонгор, Бөмбөгөр сумын Буйлсан, 2009**

Хуурай аргаар баяжуулж байгаа тохиолдолд үлээлгэх хурд хүчийг сайн тохируулж амны хаалт, битүү нүдний шил хэрэглэж хэвших шаардлагатай. Гол нь хөрс хуулалтаас гарсан алтны агуулгагүй шороо, чулуу, баяжуулалтаас гарсан хаягдлыг олборлолтын газраас дор хаяж 5 метрийн зайд овоолго үүсгэн хурааж байгаад тухайн газарт олборлолт хийж бүрэн дууссаны дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн батлагдсан зааврын дагуу эргүүлэн хэрэглэж хэвших нь чухал юм. Хуурай баяжуулалтанд ашиглах үлээгч моторын (цилиндрүүдийн нийлбэр) багтаамж нь  $500 \text{ см}^3$  –ээс илүүгүй байх ёстой. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг бодолцож үзвэл хуурай аргаар баяжуулах нь илүү үр дүнтэй бөгөөд гагцхүү өөрийгөө хамгаалах хэрэгсэл байнга хэрэглэх шаардлагатай.

Гүний уурхайгаас олборлосон алтны хүдрийг зориулалтын баяжуулах үйлдвэрт баяжуулах нь зүйтэй. Одоогийн байдлаар Төв аймгийн Борнуур суманд мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулах цех ажиллаж, зөвхөн Төв аймгийн бичил уурхайчдаар зогсохгүй бусад аймаг сумдаас ирсэн бичил уурхайчдын хүдрийг баяжуулах үйлчилгээ үзүүлж байна. Үүнтэй ижил үйлчилгээ явуулах баяжуулах цехүүдийг Сэлэнгэ аймгийн Мандал, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумдад байгуулах бүтээн босголтын ажил явагдаж байна.



### 6. Борнуурын баяжуулах цех

Мөнгөн усаар алт бариулах аргыг хатуу хориглодог. Мөнгөн ус нь маш бага температурт ууршин, мөнгөн усны дутуу исэл үүсгэдэг бөгөөд ийм исэл холилдсон агаар бүхий орчинд байгаа хүний амьсгалаар биенд ороход хордлого өгч цаашид хадгалагдсанаар оюун ухаан самуурах, удмын гажиг илрэх, хүнд ужиг өвчин тусах эрсдэлтэйгээс гадна энэ нь хэд хэдэн үе дамжин үргэлжилэх аюултай.



## 2. Нөхөрлөл бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах

### Сумын Засаг даргатай гэрээ байгуулах

Нөхөрлөл байгуулагдаж шаардлагатай бичиг баримтаа бүрдүүлсний дараа олборлолт явуулах талбайгаа тухайн сумынхаа газар нутаг дээр тодорхойлно. Дээр өгүүлсэнчлэн нөхөрлөл бүртгүүлсэн газраасаа өөр газарт бичил уурхайгаар олборлолт явуулах болон газар хүссэн өргөдөл гаргах эрхгүй. Харин сум дотроо 1) ашиглалтын болон технологийн хаягдлаар үүссэн орд буюу урьд нь компанийн шугамаар олборлолт явуулж байгаад орхисон талбай болон 2) эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон буюу компанийн зохион байгуулалтаар олборлох, техник, тоног төхөөрөмж хэрэглэхэд эдийн засгийн үр ашиггүй бага хэмжээний нөөцтэй талбайд олборлолт хийх хүсэлт гаргаж болно.



### 7. Баянхонгор аймгийн Жаргалант сумын нөхөрлөлүүд сумын ЗД болон бусад талуудтай гэрээ байгуулж байгаа нь, 2009

Тодорхой талбайг дээрх шаардлагын дагуу сонгосны дараа сумын Засаг даргын Тамгын газраас батлагдсан өргөдлийн маягт авч бөглөөд доорх бичиг баримт, материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:

- Гишүүдийн иргэний үнэмлэхний хуулбар
- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлсөн дэвтрийн хуулбар

- Орлогын албан татвар төлөгчийн гэрчилгээний хуулбар
- Батлагдсан маягтын дагуу олборлолт явуулах газрын байршлын зураг (уг зураглалд тухайн орчны дүрслэл, ямар зориулалтаар хэрэглэж байсан, гол горхи, булаг шанд, худаг байсан эсэх, машин болон зөрөг зам байсан эсэх гэх мэт мэдээллийг багтаасан байхаас гадна ургамалжилтын талаарх мэдээллийг оруулна)

Ийнхүү бүрдүүлсэн материалаа сумын Засаг даргын Тамгын газар өгсний дараа танай нөхөрлөлд Засаг даргаас хариуг дараах хоёр байдлаар өгч болно:

- Сум өөрсдийн иргэддээ бичил уурхай эрхлэх боломжтой газрыг сонгож ашигт малтмалын газарт шалгуулж дүгнэлт гаргуулчихсан бол танай нөхөрлөлийн өргөдлийг хүлээж авснаас хойш **2 долоо хоногийн дотор** шийдвэрээ мэдэгдэнэ. Гол нь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг дарга бичил уурхайд зориулж газар сонгоод дүгнэлтийг нь Ашигт малтмалын газраар гаргуулчихсан нөхцөлд.
- Харин таны сонгосон газар тухайн сумын хувьд дүгнэлт гаргуулаагүй газар бол илүү хугацаа орно. Таны өргөдлийг хүлээн авснаас хойш сум **6-8 долоо хоногийн дотор** шийдвэрлэж өгөх үүрэг хүлээсэн байгаа. Энэ хугацаанд уг хүсэлт гаргасан нөхөрлөл ямар ч олборлолт явуулах эрхгүй байна.

Засаг дарга тухайн нөхөрлөлийн хүсэлтийг хүлээж авсан бол зөвшөөрсөн болон татгалзсан аль ч нөхцөлд заавал эргэж хариу мэдэгдэх ёстой.

Татгалзсан нөхцөлд ямар шалтгаанаар татгалзах болсоноо сумын Засаг дарга нөхөрлөлд заавал мэдэгдэх ёстой.

Харин зөвшөөрсөн тохиолдолд сумын Засаг дарга нөхөрлөлтэй батлагдсан маягтын дагуу гэрээ байгуулна. Гэрээ байгуулахаас өмнө сумын байгаль орчны байцаагчтай хамтарч тухайн олборлолт явуулах газрын байгаль орчны ерөнхий үнэлгээг нягтлан үзэж байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу хийнэ. Мөн уг төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн дундын сан байгуулах, зарцуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг тусгаж өгнө. Сумын Засаг дарга болон тухайн нөхөрлөлийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч гэрээ байгуулснаар гэрээ хүчин төгөлдөр болж олборлолт явуулах боломжтой болно.





## **Гурвалсан болон олон талт гэрээ байгуулах**

Хэрэв тухайн суманд бичил уурхайгаар олборлолт явуулах газар байхгүй тохиолдолд эсвэл ашиглалтын “А” лицензтэй компанийн талбайд бичил уурхайчид олборлолт явуулахаар тохиролцоонд хүрсэн бол сумын Засаг дарга, Ашиглалтын лиценз эзэмшигч компани болон нөхөрлөл хоорондоо гурвалсан гэрээ хийж болно. Хэрэв тухайн суманд бичил уурхайгаар олборлолт явуулах газар байхгүй бол ямар нэг бичил уурхайн үйл ажиллагаа тухай ярих ч хэрэггүй болох нь ойлгомжтой.

Нэг талаар талууд тохиролцож чадвал гурвалсан гэрээ нь хамгийн шуурхай, үр дүнтэй үйл ажиллагааны хэлбэр байдаг боловч нөгөө талаар тохиролцож чадахгүй бол тухайн суманд үл ойлголцол, зөрчлийг бий болгодоогоороо дэмжүүштэй хэлбэр бас биш юм. Гурвалсан гэрээ байгуулах нөхөрлөлүүд хамтарч өөрсдийг нь төлөөлж чадахуйц аль нэг төрийн бус байгууллагаар дамжуулан хэлцэл хийж, тохиролцох нь илүү үр дүнтэй байдаг. Гол нь нэг нөхөрлөл бус олон нөхөрлөл тухайн лицензтэй талбайд олборлолт явуулахаар зэрэгцэн өрсөлдөж байдгаас болж компаниуд аль нэг нөхөрлөлтэй дангаар нь гэрээ хийхийг эрмэлздэггүй. Тиймээс ашиг сонирхлынхоо төлөө нөхөрлөлүүд нэгдсэн дуу хоолойтой байж хамтарч хэлэлцэх нь үр дүнд хүргэнэ.

Лицензтэй компани нөхөрлөлүүдийн нэг адил нөхөн сэргээлт, аюулгүй ажиллагаан дээр хариуцлага хүлээдэг тул хариуцлагагүй нөхөрлөл болон ТББ-тай гэрээ хийх сонирхолгүй байдаг. Иймээс нөхөрлөлүүд хариуцлагаа сайжруулж, албан ёсны хуулийн этгээдээр, тухайлбал ТББ-аар зуучлагч байгууллагаа болгож оролцох боломжтой.

Гурвалсан гэрээний үлгэрчилсэн загварыг АМГ-аас баталсан. Уг загварын дагуу гурвалсан гэрээ байгуулахдаа нөхөрлөл шаардлагатай баримт бичгийг мөн хавсаргана. Уг баримт бичигт:

- Гишүүдийн иргэний үнэмлэхний хуулбар (тухайн сумын иргэн оршин суугч байна)
- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлсөн дэвтрийн хуулбар
- Орлогын албан татвар төлсөн гэрчилгээ орно.

Гурвалсан гэрээ байгуулснаар сумын Засаг дарга гэрээний биелэлтэд илүү хяналт тавих эрхтэй болдог. Түүнчлэн талууд гэрээнээс гарах үндэслэлүүдийг уг “үлгэрчилсэн загвар”-т тодорхой тусгаж өгсөн байгаа.

### **3. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах**

Хэдийгээр энгийн иргэд зохион байгуулалтанд орж олборлолт явуулж байгаа ч бичил уурхай нь эрсдэл ихтэй учир аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын талаар тодорхой мэдлэг туршлага, хатуу сахилга батыг бичил уурхайчдаас шаарддаг. Нөхөрлөл олборлолт явуулахдаа АМГ-аас баталсан “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг ягштал баримталж ажиллах шаардлагатай. Сумын Засаг даргатай эсвэл гурвалсан гэрээ байгуулсан аль ч тохиолдолд уг дүрмийг баримталж ажиллах үүргээс чөлөөлөгдөхгүй. Түүнчлэн “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Хүдрийн ба, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдөж ажиллана. Эдгээр дүрэм журмыг АМГ, аймаг сумын Засаг даргын Тамгын газар, түүнчлэн “Тогтвортой бичил уурхай” төслөөс авч танилцаж болно.

#### **Аюулгүй ажиллагааны зааварчилгаа**

Дээрх дүрэм журмыг нөхөрлөлийн гишүүд уншиж танилцах бөгөөд нөхөрлөлийн ахлагч гишүүдэд тогтмол зааварчилгаа өгөх ажлыг гардан гүйцэтгэнэ. Ахлагч гишүүдэд аюулгүй ажиллагааны анхан шатны урьдчилсан зааварчилгааг анх ажил эхлэхэд, мөн ажлын өдөр эхлэх бүрт гүйцэтгэж буй ажилтай нь уялдуулан тогтмол өгч байх үүрэг хүлээсэн байдаг.

Түүнчлэн улирал тутам урьдчилсан зааварчилгааг гишүүдэд дахин өгч байх нь тухайн бичил уурхайн олборлолтын явцтай уг зааварчилгаа уялдан шинэчлэгдэж байх бололцоог олгоно. Бичил уурхайд нөхөрлөлийн гишүүд ахлагчийн зөвшөөрөл, зааварчилгаагүйгээр ажиллахыг хориглоно. Тухайн өдөр нөхөрлөлийн гишүүний эрүүл мэндийн байдал, архи уусан болон хамгаалах хэрэгсэл өмссөн эсэх зэрэг бичил уурхайн аюулгүй ажиллагааг шалгасны дүнд нөхөрлөлийн ахлагч гишүүдэд ажиллах зөвшөөрөл өгч хэвших нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм баримталж хэвших эхний алхам юм. Нөхөрлөлийн ахлагч энэ үүргийг хүлээн авсанаараа бас хариуцлага хүлээдэг.

Нөхөрлөлийн гишүүд өөрсдийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд уурхайд ажиллахаар орохдоо шалгах хамгийн энгийн таван асуулыг өөртөө тавьж, хэрэв нэг нь л зөрчигдөж байвал уг зөрчлийг арилгах арга хэмжээг нөхөрлөлийн



гишүүд хамтдаа нэн даруй арилгаж хэвших хэрэгтэй. Эдгээр асуулт нь:

1. Ажлын байранд орох орчинг шалгасан уу?
2. Ажлын байр аюулгүй мөн хэрэглэгдэх багаж хэрэгсэл бүгд бүрэн байна уу?
3. Аюулгүй байдлыг хангах горимын дагуу ажиллаж байна уу?
4. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан уу?
5. Цаашид аюулгүй ажиллагааны горимын дагуу үргэлжлүүлэн ажиллаж чадах уу?

Агаар дутмаг болон хорт хийтэй нүх болон гүний уурхайд агааржуулагч заवाल хэрэглэж хэвших шаардлагатай. Мөн ухсан нүх болон ил амыг тойруулан хаалт хашилт барьж хүн, мал унаж бэртэх, амь насаа алдахаас сэргийлэх шаардлагатай. Эдгээр бүх шаардлагууд нь бичил уурхайчдын гэмтэж бэртэх, амь, нас эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн бөгөөд цаашид уг нөхөрлөл үйл ажиллагаагаа хуулийн дагуу, тогтвортой явуулах баталгаа болдог.

### **Уул уурхайн аврах баг байгуулах**

Нөхөрлөлийн гишүүд сайн дурын үндсэн дээр дундаасаа аврах баг байгуулж ажиллахыг орон нутаг, уул уурхайн аврах албанаас дэмжиж ажиллах болсон. Энэ баг нь зэргэлдээ болон өөрийн нөхөрлөлийн талбайд ямар нэгэн осол гарсан тохиолдолд хүний амь насыг аврах ажиллагаанд сайн дураараа ордог бөгөөд аврах ажиллагааны арга зүй, сургалтыг сумын Засаг даргын тамгын газар болон Уул уурхайн аврах албанаас (УУАА) тогтмол давтамжтайгаар зохион байгуулдаг. Бичил уурхайчдын ТББ байгуулагдсан бол уг байгууллага сайн дураараа аврах багт орсон залуусыг сургах, хувцас хэрэглэлээр хангахад нь ЗДТГ болон УУАА-тай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлдэг. Аврах багийн гишүүд эрүүл чийрэг, бичил уурхайн үйл ажиллагааны талаар мэдлэг туршлагатай, аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдсан, гол нь бичил уурхай эрхэлдэг, тухайн талбай дээр тогтмол ажилладаг хүн байх нь чухал юм. Амьдарлын зөв хэвшилтэй, согтууруулах ундаа хэрэглэдэггүй, ажлын өндөр хариуцлагатай хүн байх нь шаардлагатай үед тухайн хүний тусламжийг цаг алдалгүй авах гол нөхцөл болно. Аврах багийн гишүүдэд олгох урамшууллыг нөхөрлөлийн ахлагчид хоорондоо зөвлөлдөж шийдвэрлэнэ. Сар тутмын тогтмол урамшууллыг бий болгосноор уг бичил уурхайн талбайд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөж ажиллахад давхар хяналт бий болох боломж бүрдэх юм.



**8. Сэлэнгийн Мандал, Баянхонгорын Бөмбөгөр сумын бичил уурхайчдын аврах баг, 2009**

#### **4. Байгаль орчны нөхөн сэргээлт хийх**

Нөхөрлөл анх Засаг даргатай гэрээ байгуулахдаа олборлолт явуулсан газартаа нөхөн сэргээлт хийх үүрэг хүлээдэг. Мөн гурвалсан гэрээ байгуулах тохиолдолд уг гэрээнд нөхөн сэргээлтийг талууд хэрхэн хийх, хүрээх үүрэг хариуцлагыг нарийвчлан зааж өгөх ёстой. Тиймээс уг нөхөн сэргээлт хийх зардлыг олборлолт явуулахаас өмнө болон олборлолтын явцад нөхөн сэргээлтийн дундын санд хуримтлуулна. Нөхөн сэргээлтийг Ашигт малтмалын газраас 2011 онд гаргасан “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар” –ын дагуу явуулна.

Уг зааварт:

1. Ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд болон
2. Эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд илрэлүүдэд бичил уурхай эрхэлсэн тохиолдолд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зааврыг нарийвчлан зааж өгсөн байдаг.

#### **Олборлолтын талбайн байгаль орчны ерөнхий байдлын үнэлгээ, зураг (өөрсдөө хийх)**

Нөхөрлөл тухайн олборлолт явуулах талбайнхаа байгаль орчны ерөнхий байдлыг “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар” –т хавсаргасан 7 зүйл бүхий хүснэгтийн дагуу бөглөж тодорхойлно. Үүнд:



1. Олборлолт явуулах газрын нэр, байршлын гар зураг
2. Газар нутгийн ерөнхий байдал: уулархаг, цөлөрхөг, тал хээр, гуу жалга, гэх мэт
3. Ашиглаж байсан зориулалт
4. Гол горхи, булаг шанд
5. Худаг
6. Машин болон хүн малын мөрөөр гарсан зам, зөрөг
7. Ургамлын төрөл

Эдгээрийг урьдчилан тодорхойлж, боломжтой бол фото зургаар баримтжуулж авах нь зүйтэй. Энэхүү ерөнхий байдлын үнэлгээ нь олборлолт явуулж дууссаны дараа нөхөн сэргээх үед харьцуулж гүйцэтгэлийг дүгнэхэд хэрэглэгдэнэ. Тиймээс эхнээс нь баримтжуулахгүй бол олборлолт явуулахаас өмнө эвдрэлд орсон газруудын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн нөхөрлөл дангаараа гүйцэтгэх шаардлагатай болно. Үг ерөнхий байдлын үнэлгээгээг фото зургаар баримтжуулж орон нутгийн Байгаль орчны улсын байцаагч юмуу бичил уурхайн асуудал эрхэлсэн ажилтнаар хянуулж гарын үсэг зуруулж авах нь цаашид гарах үл ойлголцлоос урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой.

### **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гаргах**

Дээрх байгаль орчны ерөнхий байдлын үнэлгээг нөхөрлөлийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-нд хавсаргаж, “Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар” –т хавсаргасан хүснэгтийн дагуу төлөвлөнө. Үг төлөвлөгөөнд дараах гурван зүйлийг заавал тусгана. Үүнд:

1. Тухайн бичил уурхайгаар олборлолт явуулах жил, улиралд хуулах/ухаж гаргах хөрс, шорооны хэмжээ, хүдэр болон ашигт малтмалын агуулга бүхий шорооны хэмжээ,
2. Тухайн жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, хуулах хөрсны талбайн хэмжээ, зарцуулах хөрөнгийн хэмжээг урьчилан тооцож төлөвлөх,
3. Мөн гүйцэтгэлийг уг төлөвлөгөөнд нөхөж бичих байдлаар ард нь оруулж өгнө.

Бичил уурхайгаар олборлолт явуулах талбайг хаана авснаас шалтгаалж өөрөөр хэлбэл 1) ашиглалтын болон технологийн хаягдлаар үүссэн үүсмэл орд буюу урьд нь компанийн шугамаар олборлолт явуулж байгаад орхисон эсвэл олборлолт явуулж байгаа компанийн эвдэгдсэн талбайд олборлолт явуулахаар гурвалсан


гэрээ байгуулсан, 2) эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд илрэлүүд буюу урьд нь ямар нэг олборлолт явуулж байгаагүй, хөрс нь эвдэгдээгүй газар бичил уурхайгаар олборлолт явуулахаар нөхөрлөл гэрээлж авсан тохиолдолд нөхөн сэргээлтийг явуулахдаа хөрс хуулалт хийх шаардлага арай өөрөөр тавигдана.

Үүнээс шалтгаалж байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг өөр өөрөөр гаргаж болно. Түүнчлэн олон бичил уурхайн нөхөрлөл зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд орон нутгийн захиргаанаас нэгдсэн нөхөн сэргээлт хийхээр шийдвэрлэвэл нөхөн сэргээлтийн дундын санг зарцуулах эрхийг орон нутагт шилжүүлж болно.

### **Нөхөн сэргээлтийн дундын сан байгуулах**

Нөхөрлөл бичил уурхай эрхлэхээр Засаг даргатай эсвэл Засаг дарга болон тухайн ашигт малтмалын лиценз эзэмшигчтэй гурвалсан гэрээ байгуулсан бол аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах бөгөөд нөхөн сэргээлтийг ашиглалтын явцад болон ашиглалт дууссаны дараа хийж гүйцэтгэнэ. Уг зардлыг нөхөрлөл болон Засаг дарга нар дангаараа захиран зарцуулах эрхгүйгээр дундын санд төвлөрүүлэх бөгөөд олборлолтын явцад бүрдүүлж мөн нөхөн сэргээлтийг график, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ. Тухайн газарт нөхөн сэргээлт хийлгүй орхисон тохиолдолд сумын Засаг дарга уг сангийн хөрөнгөөр нөхөн сэргээлтийг явуулна. Гаргах зардлыг нөхөрлөл гэрээ байгуулж байгаа талуудтай хамтран тооцох бөгөөд нөхөрлөл дундын санд бүрдүүлнэ. Бичил уурхайн гэрээ байгуулсны дараах хоёр долоо хоногт нөхөн сэргээлтийн дундын санг байгуулж нөхөн сэргээлтийн нийт зардлын 10 хувийг байршуулдаг. Нөхөн сэргээлтийн дундын санг бүрдүүлж тусгай дансанд байршуулах график төлөвлөгөөг “бичил уурхайгаар йшигт малтмал олборлолт гэрээ”-нд болон байгаль хамгаалах төлөвлөгөөнд хавсаргаж өгдөг. Нөхөрлөлийн гишүүд энэ асуудлыг өөрсдийн хамтын ажиллагааны гэрээнд зайлшгүй тусгасан байна.

Бичил уурхайгаар олборлолт явуулах явцад уурхайчид олборлолт явуулж буй газраа тогтмол нөхөн сэргээх бөгөөд талбайг хүлээлгэж өгөхдөө өөрсдийн бүрдүүлсэн дундын сангаас нөхөн сэргээлтэнд зарцуулсан мөнгийг буцааж авах боломжтой. Үүний тулд тухайн орон нутгийн байгаль орчны байцаагчид нөхөн сэргээлт



**9. Хөрс хуулалт болон нөхөн сэргээлтийн зураг. Жаргалант, Баянхонгор, 2009**

хийсэн газраа шалгуулж, зөвшөөрөл авмагц Засаг даргаар гарын үсэг зуруулж дундын сангаас өөрсдийн зарцуулсан мөнгөн хөрөнгийг байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу буцаан авна.

Нөхөн сэргээлтийн санг арилжааны банкинд харилцах данс/ хадгаламж хэлбэрээр эсвэл эскроу дансны хэлбэрээр байгуулж болох бөгөөд нэгдүгээр гарын үсгийг Засаг дарга, хоёрдугаар гарын үсгийг нөхөрлөлийн ахлагч зурна. Уг данс нь нэг гарын үсэгтэй байж болохгүй. Орон нутагт хэрхэн зохицуулж байгаагаас шалтгаалан Засаг даргын тамгын газраас хэнийг тухайн дансны нэгдүгээр гарын үсэг зурах хүнээр сонгохыг шийдвэрлэж болдог.

Түүнчлэн ТББ-аар дамжуулан гэрээ хийсэн тохиолдолд дундын санг хэрхэн бүрдүүлэх, хэнийг хоёрдугаар гарын үсэг зурах хүнээр томилохыг нөхөрлөлүүд, ТББ-тайгаа зөвшилцөж шийдвэрлэнэ.



### **Ашиглалтын болон технологийн хаягдалаар бий болсон үүсмэл ордод нөхөн сэргээлт хийх** *(урьд нь эвдэгдсэн газар)*

Хэдийгээр урьд нь өөр компани болон хувь хүмүүс тухайн газар дээр олборлолт явуулж байсан ч гэсэн уг бичил уурхайгаар олборлолт явуулах гэрээ байгуулсан нөхөрлөл нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөгдөхгүй. Харин техникийн нөхөн сэргээлтийг ямар түвшинд, биологийн нөхөн сэргээлтийг хэрхэн явуулах зэргийг орон нутаг, байгаль орчны байцаагчтайгаа тохиролцоно. Уг газрыг нөхөн сэргээсний дараа орон нутаг хэрхэн ашиглах зориулалтаар нь нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ. Хөдөө аж ахуй (бэлчээр, хадлан тариан талбай), ойн аж ахуй (хамгаалалтын зурвас үүсгэх, ойжуулалтын үрсэлгээний талбай), усны аж ахуйн зориулалтаар тухайн газрыг нөхөн сэргээдэг.



**10. Техникийн нөхөн сэргээлт, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Буйлсан, 2009**

Техникийн нөхөн сэргээлт хийхдээ тухайн газрын геологийн тогтцын үечлэлийн дагуу гарсан хаягдал чулуулаг, шороог буцааж булах бөгөөд үржил шимт хөрсөөр хучиж байгалийн хуучин хэлбэр тогтцонд нь оруулж тэгшилдэг. АМГ-аас гаргасан нөхөн сэргээлтийн заавар болон холбогдох стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ.

Биологийн нөхөн сэргээлтийг хавар буюу 5-6 сард явуулахаар заасан байдаг. Нөхөрлөлийн гэрээний хугацаа уг улирал эхлэхээс өмнө дуусах бол эсвэл орон нутаг өөрсдөө нэгдсэн журмаар явуулах тохиолдолд дундын сангаас биологийн нөхөн сэргээлтэнд





хуваарилсан хөрөнгийг орон нутагт шилжүүлнэ. Тохиролцож чадаагүй бол нөхөрлөл уг газартаа биологийн нөхөн сэргээлт явуулах хугацаанд нь нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, байгаль орчны байцаагч шалгасны дараа сумын Засаг даргад хүлээлгэн өгч гэрээгээ дуусгавар болгоно. Хэрэв гурвалсан гэрээ байгуулсан бол нөхөрлөлүүд нөхөн сэргээлтийн зардлыг байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу дундын санд хуримтлуулна. Нөхөн сэргээлтийг хэрхэн гүйцэтгэхийг гурвалсан гэрээндээ тусгана.

### **Эдийн засгийн үр ашиггүйд тооцогдсон орд илрэлүүдэд нөхөн сэргээлт хийх** *(эвдэгдээгүй газар)*

Ийм төрлийн газар бичил уурхайгаар олборлолт явуулах гэрээ хийсэн нөхцөлд хөрс хуулалт явуулахад нэмэлт шаардлага тавигддаг. Өөрөөр хэлбэл үржил шимтэй өнгөн хөрсийг хуулж олборлолтын амнаас дор хаяж 5 метр зайнд нийлүүлж овоолго босгох бөгөөд энэ нь ус, бороонд урсах болон салхинд хийсэхээс хамгаалах зорилготой. Бусад шороо, чулуулгийг 1) үл хөрсний чулуулаг болон 2) үржил шимгүй шороогоор ангилж тус тусад нь овоолго үүсгэн, нөхөн сэргээлт хийхдээ эдгээр шороог геологийн тогтоцохын нь дагуу эргүүлж дүүргэлт хийж булдаг.

Засаг даргатай байгуулсан гэрээ болон гурвалсан гэрээгээр олборлолт явуулах нөхцөлд аль алинд нь **дээр дурдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлт болон хөрс хуулах** үйл ажиллагааг явуулах бөгөөд биологийн нөхөн сэргээлтийг заавал хийж гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлтийн ажлыг хэн гүйцэтгэхийг тохиролцож, гурвалсан гэрээнд тусгаж өгөх бөгөөд ерөнхий хариуцлагыг компани хүлээхээр зохицуулагдсан байдаг. Учир нь тухайн ашиглалтын лицензтэй компани хуулийн дагуу нөхөн сэргээлтийг гүйцэтгэх ёстой.

## **2. Бичил уурхайн Төрийн бус байгууллага (ТББ)**

### **ТББ-ын зорилго**

Бичил уурхайчдын ТББ нь бичил уурхайчдын нийтлэг эрх ашиг, сонирхлыг хамгаалах, нийгэм, эдийн засаг, байгаль орчин болон бусад асуудлуудыг хамтын хүч, бусдын дэмжлэгтэйгээр шийдвэрлэх зорилгоор сайн дураар эвлэлдэн нэгдсэн бичил уурхайчид, нөхөрлөлүүдийн үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд ашгийн бус үйл ажиллагаа явуулдагараа компаниас ялгаатай юм.



**11. Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар, Баянхонгор аймаг 2010**

ТББ-ын үндсэн зорилго нь гишүүддээ үйлчлэх, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гишүүдийнхээ санал бодол, дуу хоолойг төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад хүргэх, хамтын ажиллагаа, ойлголцлыг бий болгоход чиглэгдэнэ.

### **Бичил уурхайчид ТББ-ын гишүүн нь болж нэгдэх нь чухал**

Бичил уурхайн асуудал зөвхөн орлого олох асуудал биш бөгөөд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсноор бичил уурхайчдын бүх асуудал шийдэгдэхгүй юм. Бичил уурхайчдын эрүүл мэнд, боловсрол, аюулгүй ажиллагаа, үр ашигтай техник технологи, хүний эрх, нийгэм, баялгийн хүртээмж, байгаль орчны бохирдол, нөхөн сэргээлт үүнтэй холбоотой зөрчлийг зохицуулах гэх зэрэг тулгамдсан олон асуудал бий. Наад зах нь газрын асуудлыг орон нутаг шийдвэрлэхгүй байх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, бичил уурхайчид болон нөхөрлөлүүд тухайн орон нутагт ашигт малтмал худалдаж авах, боловсруулах, бичил уурхай эрхлэхэд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг хувийн компаниудтай хэлэлцээр хийх, уул уурхайн том компанитай гурвалсан гэрээ хийж хамтран ажиллах зэрэг бичил уурхайчдад нийтлэг тохиолддог асуудлуудыг нөхөрлөлийнхөн дангаар шийдвэрлэхийг зорих нь мэдээж олон төрлийг бэрхшээлийг араасаа дагуулна. Иймд бичил уурхайчид бусад оролцогч талуудтай идэвхитэй хамтран ажилласнаар дээрх асуудлуудыг зүй зохистой шийдвэрлэх боломж бүрдэнэ.



Энэ мэтчилэн бичил уурхайчдад тохиолддог хамгийн түгээмэл асуудлуудыг шийдвэрлэх, эвлэлдэн нэгдэж хамтын хүчээр амжилтанд хүрэх, нэгдсэн нэг хүсэл зоригоор өөрсдийн оршин суудаг орон нутгаа хөгжүүлэх зорилгоор бичил уурхайчид ТББ байгуулж, гишүүн нь болдог.

Бичил уурхайн ТББ нь гишүүддээ:

1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах;
2. Бичил уурхайн олборлолтын стандартыг мөрдөх;
3. Олборлолтонд хэрэглэх тоног төхөөрөмжийн хэрэглээ, тавигдах шаардлага зэргийг тайлбарлан таниулах;
4. Санхүүгийн дэмжлэг, зээл авах;
5. Баяжуулах үйлдвэр, цехтэй гэрээ хийх;
6. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудтай холбож өгөх;
7. Тоног төхөөрөмж нийлүүлдэг (тэсэлгээ хийдэг тусгай зөвшөөрөл бүхий) компаниудтай холбох;
8. Байгаль орчны нөхөн сэргээлт хийх;
9. Хөрөнгө босгох зэрэг үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлж ажилладаг байх шаардлагатай. Дээрх үйл ажиллагааг явуулахын тулд ТББ байгууллага нь дотоод ардчилалтай, үйл ажиллагааны сайн менежменттэй, санхүүгийн хувьд тогтвортой байх хэрэгтэй бөгөөд доорх асуудлуудыг юуны түрүүнд үйл ажиллагаандаа тусгасан байх хэрэгтэй.

### ***ТББ-ын хэлбэрийг сонгох учир нь***

Нийгэмд өөрсдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, бусдад хүлээн зөвшөөрүүлэхийн тулд гишүүдийнхээ нийтлэг эрх ашиг, сонирхлыг хамгаалан нэгдэж, тэднийг төлөөлөх, нийгмийн харилцаанд орох чадавхи бүхий хуулийн этгээд байх нь бичил уурхайчдын ТББ-ын гол шалгуур үзүүлэлт юм.

### **ТББ-ын нийтлэг үүрэг**

Гишүүддээ үйлчилгээ үзүүлэх, чадваржуулах арга хэмжээг зохион байгуулах, гишүүдийнхээ үзэл бодол, хүсэл сонирхлыг төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад хүргэх, хамтын ажиллагааг бий болгох.

*Бичил уурхай эрхлэгч гишүүдээ үйлчилгээ үзүүлэх, чадавхижуулах, мэдээллээр хангах, зохион байгуулалтанд оруулахад туслалцаа үзүүлэх*

Энэ ажлын хүрээнд ТББ бүх гишүүдийнхээ хурлыг өөрийн орон нутаг, үйл ажиллагааныхаа онцлогоос хамаарч боловсруулсан

тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулж үйл ажиллагааныхаа талаар холбогдох мэдээллийг хүргэн, шаардлагатай шийдвэрийг гаргах, сургалт сурталчилгааны ажил явуулах замаар гишүүдийнхээ чадавхийг дээшлүүлэх үүрэгтэй.

***Бичил уурхайчдын аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр ажил зохион байгуулах***

ТББ, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах замаар гишүүдийнхээ ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг дагаж мөрдөхийн ач холбогдлыг ойлгуулах, хамгаалалтын хувцас хэрэгслийг тогтмол хэрэглүүлж заншуулах талаар сургалт, сурталчилгааны төрөл бүрийн ажил зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих үүрэгтэй.

***Орон нутагтаа хамтын ажиллагааг бэхжүүлэх***

Бичил уурхайчид орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа болохоор тэдний эрх ашгийг хамгаалах, сонирхлыг нь дэмжих, хамтын ажиллагаа бий болгох үйл явц тухайн орон нутагт өрнөдөг. Тиймээс ТББ-ууд орон нутгийн төрийн захиргааны болон бусад ТББ-уудтай хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцэлийг бий болгосноор нийт бичил уурхайчдын өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд дөхөмтэй болно.

**ТББ-ын хариуцлага**

Бичил уурхайчдын ТББ нь төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх, гарсан үр дүнг бататгах, тогтмолжуулах талаар хариуцлага хүлээнэ.

**Төрийн бус байгууллагын удирдах байгууллага**

- Гишүүнчлэлтэй төрийн бус байгууллагын эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.
- “ТББ-ын тухай хууль”(1997)-ийн дагуу бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг нь байгууллагын дүрмээр зохицуулна.
- Гишүүнчлэлтэй ТББ-уудын эрх барих эрхийг бүх гишүүдийн хуралд эдэлж, харин хурлын чөлөө цагт Удирдах зөвлөлдөө эрх барих буюу шийдвэр гаргах эрхийг шилжүүлсэн байдаг.
- Удирдах зөвлөл бол ТББ-ын сонгуульд удирдлага юм.

Гишүүнчлэлтэй байгууллага Удирдах зөвлөлд эрх мэдлийн төлөөлөл шилжүүлж байгаа нь эрх мэдлийг хуваарилж, асуудлыг шуурхай шийдвэрлэх, уян хатан, цомхон механизмыг бүрдүүлж байгаа хэрэг юм.



**12. Бөмбөгөр сумын “Баянбөмбөгөр” сумын ТББ-ын бүх гишүүдийн хурлын зар**

### **Удирдах зөвлөлийн шийдвэр гаргах журам**

- ⇒ Удирдах зөвлөлийн гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байна.
- ⇒ Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ.
- ⇒ Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар УЗ-ийн гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.
- ⇒ Гишүүдийн олонхийн, ердийн олонхийн, дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ гэх мэт. Санал тэнцсэн тохиолдолд хурлын дарга эцсийн шийдвэрийг гаргах эрхийг эдлэхийг тусгадаг.

### **Удирдах зөвлөлийн ерөнхий чиг үүрэг**

- ⇒ Байгууллагын зорилго, зорилтуудыг тодорхойлох
- ⇒ Стратеги зорилтуудыг хэрэгжүүлэх
- ⇒ Байгууллагыг манлайллаар хангах
- ⇒ Гүйцэтгэх захирлыг томилох, үнэлэх, чөлөөлөх
- ⇒ Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг дэмжин туслах
- ⇒ Санхүүгийн бодлогыг боловсруулах
- ⇒ Байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хяналт тавих
- ⇒ Байгууллагыг олон нийт, Засгийн газартай холбох
- ⇒ Хөрөнгө босгох үйл ажиллагааг удирдах

### **Удирдах зөвлөл ТББ-ын хуулийн дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ**

- ⇒ Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- ⇒ Байгууллагын жилийн төсөв батлах;
- ⇒ Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;
- ⇒ Төрийн бус байгууллагын өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын эрх, хэмжээг тогтоох;
- ⇒ Төрийн бус байгууллагын ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг батлах;
- ⇒ Дүрэмд заасан бусад бүрэн эрх.

### **Удирдах зөвлөлийн хурал**

Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх хурлаар дамжин хэрэгжинэ. Удирдах зөвлөлийн хуралд хэлэлцэх асуудлаа тодорхой, ойлгомжтой томъёолох нь хамгийн чухал байдаг. Үүний тулд

1. Удирдах зөвлөлийн хурлын төлөвлөгөө
  - Гишүүдийн үнэлгээнд тулгуурласан бодлогын хэрэгжилтийн дүн шинжилгээ
  - Гишүүдийн саналд үндэслэсэн цаашдын хөгжлийн стратегийн төсөл
2. Хурлын оролцоог бүрэн хангахуйц урьдчилсан зар /Хурал болох цаг хугацаа, байр, хэлэлцэх асуудал, санал авахтай холбоотой мэдээ, материал гэх мэт/

Хурлын явц байдлыг баталгаажуулсан тэмдэглэл /хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар гэх мэт/

### **ТББ-ын гишүүдэд тавигдах шаардлага**

- Гишүүний татвараа төлдөг;
- Нэгдсэн зорилгоо мэддэг, нэгдмэл байр сууриа хамгаалдаг;
- Зорилгодоо үнэнч, тууштай;
- ТББ-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог;
- ТББ-аас тавих шаардлагыг хүлээн авдаг, биелүүлдэг байх

### **Санхүүжилт**

ТББ-ын орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэх бөгөөд орлогыг зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

#### ***Гишүүдийн татвар***

Бичил уурхайчдын ТББ-ын татвар хураахдаа баримтлах үндсэн зарчим нь гишүүдээсээ хураасан татварыг тэдэнд чиглэгдсэн үйл ажиллагаанд оновчтой, үр дүнтэй зарцуулахад оршдог. ТББ-ууд ихэвчлэн нэг гишүүнээс авах сарын татварын хэмжээг 1000 төгрөгөөр тогтоосон байдаг боловч энэ нь төдийлөн хангалттай биш байдаг. ТББ-ууд гишүүдийн татварын хэмжээг тогтоохдоо тухайн жилд ямар ямар үйл ажиллагаа явуулах, тэдгээрт хэдэн төгрөгний санхүүжилт



шаардагдах болон үүний хэдэн хувийг нь гишүүдийн татвараас санхүүжүүлэх саналтай байгаагаа Удирдах Зөвлөлөөрөө хэлэлцэн Бүх гишүүдийнхээ хуралд оруулан батлуулах нь зүйтэй юм.

### ***Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив***

ТББ гишүүдээсээ хандив авч болно. Жишээлбэл Баянхонгор аймгийн Баян-овоо сумын “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” ТББ-ын нөхөрлөлүүд үйл ажиллагааг нь дэмжих хандив өгсөн бол, Дорноговь аймгийн Айраг сумын “Эх орон хамтын хүч” ТББ гишүүнээр элсэн орж буй нөхөрлөлүүдээсээ 50.000 төгрөгийн хандив авах зэргээр санхүүгээ бүрдүүлдэг байна.

### ***Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого***

Төв аймгийн Борнуур сумын “Бичил уурхайчдын холбоо” ТББ хүдэр баяжуулах цех бүхий ХАМО ХХК-тай хамтран ажиллаж зарим нэгэн чиглэлээр санхүүгийн дэмжлэг авдаг бол, Баянхонгор аймгийн Жаргалант, Бөмбөгөр сумын ТББ-ууд нөхөн сэргээлт хийх трактороороо нөхөрлөлүүдэд түрээсээр хөрс хуулалт хийх үйлчилгээ үзүүлэн нэмэлт орлого олдог. Баян-овоо сумын ТББ өөрийн гэсэн цооног гаргаж түүнээсээ олсон орлогын 50%-иар үйл ажиллагаа санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа бол Бөмбөгөр сумын ТББ өөрсдийн гэсэн ногооны талбайтай болсон байна. Иймэрхүү байдлаар ТББ-ууд өөрсдөө санаачилгатай бол орлогын нэмэлт эх үүсвэртэй болох боломжууд бий.

### ***Зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олсон хөрөнгө***

Тухайн ТББ үйл ажиллагаа явуулж нутгийнхаа оролцогч талуудтай харилцаа холбоогоо хэрхэн тогтоож, хамтарч ажиллахаас тэднээс авах дэмжлэгийн цар хүрээ хамаарах нь тодорхой юм. Орон нутгийн дэмжлэгийг авахын тулд дараах 3 зүйлийг ТББ-ын удирдлагууд мэддэг байх ёстой:

1. Танай ТББ үйл ажиллагаагаа хэвийн явуулахад саад болж буй асуудал байгаа эсэх, хэрэв байгаа бол түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар болон тухайн бэрхшээлтэй асуудлыг өөрсдөө шийдвэрлэж чадахгүй байгаа учир шалтгаанаа тодорхойлсон байх нь зүйтэй. Тэгвэл танай хамт олон хэнд хандах, нөгөө тал ч юугаар, хэрхэн туслахаа ойлгох боломжтой болно.

2. Дэмжлэг зөвхөн мөнгөн хэлбэртэй байддаггүй. Тухайн асуудлаасаа хамаараад тоног төхөөрөмж, үйлчилгээ, чадавхижуулах сургалт, газар ашиглах зөвшөөрөл гэх мэтчилэн янз бүрийн хэлбэрээр байж болно.
3. Тодорхой асуудлаар төслийн санал боловсруул. Ингэвэл танай ТББ-ын санал илүү албан ёсны, итгэл үнэмшил төрүүлэхүйц болж, дэмжигдэх магадлал нэмэгдэнэ.

### **Гишүүнчлэлтэй ТББ-ын онцлог**

Гишүүнээр элсэхийн тулд тавигдах шаардлага, нөхцлүүдийг дүрмэндээ тодорхой тусгасан байна. Гишүүн нь байгууллагын үзэл баримтлал, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болохыг зааж, гишүүнчлэлийн төрлийг тодорхойлно. Тухайлбал: Хүндэт гишүүн, жирийн гишүүн гэж хэн болох, тэдгээрийн ялгаа, давуу тал, шинээр гишүүнээр элсэхийн тулд хэнд хандах, хүсэлтээ хэрхэн гаргах болон шийдвэрлэх хугацаа, гишүүний эрх, үүрэг, гишүүний татварын хэмжээ, төлбөрийн хэлбэр болон байгууллагын шийдвэр гаргах ба өдөр тутмын үйл ажиллагаанд ямар хэлбэрээр оролцож болох зэргийг тусгана.

### **Хамтын ажиллагаа**

Аливаа байгууллагын амжилтанд хүрэх эсэх нь байгууллагын гишүүд, ажилтнууд болон удирдлага хоорондын хамтын ажиллагаа, ил тод байдал, итгэлцлээс ихээхэн хамаардаг. Тиймээс байгууллагын доторхи ил тод байдлыг хангах, хамтран ажиллах таатай уур амьсгалыг бүрдүүлэх, гишүүд болон удирдлагынхаа итгэл найдварыг хүлээхийг чухалчлах хэрэгтэй.

### ***Тодорхой, ил тод байдлаар үйл ажиллагаа явуулах***

ТББ үйл ажиллагааны төлөвлөгөөгөө жил бүр нарийвчлан боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталдаг байх шаардлагатай. Ингэхдээ гишүүдийн санал, зөвлөмжийг нарийвчлан авч төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй бөгөөд энэ нь батлагдсан төлөвлөгөө хэрэгжих нэг гол нөхцөл болно. Мөн төлөвлөгөөнд ямар ямар чиглэлийн үйл ажиллагаануудыг, яагаад оруулсан, үүнээс гарах үр дүн нь юу байх вэ гэдгийг гишүүддээ маш ойлгомжтойгоор тайлбарлаж таниулан, үйл ажиллагааныхаа талаар бүрэн ойлголт өгөхийг эрмэлзэх нь чухал юм.





### ***Оролцооны аргыг ашиглан үйл ажиллагаагаа явуулах***

ТББ-аас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аливаа үйл ажиллагаандаа өөрийн гишүүдийг аль болох олноор оролцуулахыг эрмэлзэх нь зүйтэй. Байгууллагын үйл ажиллагаанд гишүүд өөрийн биеэр оролцож, хувь нэмрээ оруулах, өөрсдөө суралцах нь сонсоод өнгөрөхөөс хавьгүй илүү үр өгөөжтэй байх нь тодорхой юм. Тиймээс ТББ-ын Удирдах зөвлөл, дэд зөвлөлүүд, тэргүүн үйл ажиллагаагаа хэзээ, хаана, ямар арга барилаар, хэрхэн зохион байгуулвал олон хүнд хүртээмжтэй, үр дүнтэй болохыг сайтар бодолцож, харилцан зөвшилцөж төлөвлөгөөгөө боловсруулдаг байвал үр дүнд хүрнэ.

### ***Ил тод байдал***

Жилдээ нэг удаа бүх гишүүдийн хурал хийж, ажлаа ярьж хэвших. Ялангуяа санхүүгийн асуудал, тэр дундаа гишүүдийн татвар, хандиваас бүрдсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан, ямар үр дүнд хүрсэн болон хэрхэн зарцуулахаар төлөвлөж байгааг ил тод тайлагнах шаардлагатай. ТББ-ын нягтлан бодогч эсвэл санхүү хариуцсан ажилтан хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үлдэгдлийн талаар тодорхой тайлан бэлтгэж гишүүдэд танилцуулдаг байх, энэ талаар тэмдэглэл хөтөлж, гарын үсгээр баталгаажуулан хадгалж занших нь чухал юм.

### ***Туршлага, сургамж***

***Туршлага:*** Баянхонгор аймгийн Жаргалант сумын бичил уурхайчид 2005 онд ТББ байгуулаагүй байх үедээ тус сумын нутагт үйл ажиллагаа явуулж байсан уурхайн компаний талбай руу хулгайгаар орж олборлолт хийснээс баригдан зодуулах, гавлуулах, эсвэл өдөржин нүхэнд нуугдан шөнө ажиллах, уулаар зугтааж амьдрах зэрэг хүндрэлтэй асуудлуудтай тулгарч байснаас гадна нутгийн иргэд болон компаний хоорондын харилцаа нэгэн рүүгээ буу шагайх хэмжээнд хүртлээ муудсан ч асуудал шийдэгдээгүй байна. Харин 2008 онд бичил уурхайчид эвлэлдэн нэгдэж “Байдрагийн хөгжил” ТББ байгуулснаар олборлолтын лиценз бүхий компанитай гэрээ байгуулан 2009 онд 13 кг алтны нөөцтэй 1.2 га талбай, 2010 онд 20 кг орчим нөөцтэй 0.5 га талбайг хэлэлцээр байгуулан авч үйл ажиллагаа явуулсан бөгөөд компаний зүгээс орон нутгийн бичил уурхайчдын ТББ, гишүүдэд нөхөн сэргээлт хийх, хөрс хуулах машин техникээр туслах гэх мэт олон талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллажээ.

**Туршлага:** Төв аймгийн Борнуур сумын бичил уурхайчид 2008 онд “Борнуурын бичил уурхайчдын холбоо” ТББ байгуулж нэгдэн ажилласны үр дүнд тухайн үед үндсэн орд бүхий газар олборлолт хийдэг бичил уурхайчдын хамгийн тулгамдсан асуудал болоод байсан хүдэр баяжуулах мөнгөн үсгүй технологи нэвтрүүлэх, ашиглах ажлын эхлэлийг тавьсан ба улмаар Монгол Улсын Засгийн газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр мөнгөн үсгүй технологиор хүдэр баяжуулах цех байгуулан амжилттай ажиллуулж байна.

Мөн бичил уурхайчдын ТББ, Засгийн газар, орон нутгийн захиргаа, ШХА, болон Бороо Гоулд компаниудын хооронд байгуулагдсан 5 талт гэрээний дагуу тус сумын бичил уурхайчдад компанийн лицензтэй газраас олборлолт явуулах хэсэг газрыг олгох талаар орон нутгийн зүгээс хувь нэмэр оруулах анхны алхмыг тавьсан юм.



### **13. Борнуурын мөнгөн үсгүй технологиор хүдэр баяжуулах цех.**

**Туршлага:** Баянхонгор аймгийн Галуут сумын бичил уурхайчдын “Бат сайхан сэтгэл” ТББ-ын гишүүд дундаасаа хөгжлийн сан байгуулсан ба гишүүн тус бүр жилд 60,000 төгрөг хандивлах журам тогтоосон байна. Энэ санд хуримтлагдсан хөрөнгийг шинээр ажлын байр бий болгоход зориулах бөгөөд журмын дагуу хандиваа түрүүлж өгсөн гишүүд шинэ ажлын байрыг авах давуу эрхтэй байхаар тогтсон байна.

**Туршлага:** “Байдрагийн хөгжил” ТББ жил бүрийн 3 дугаар сард сумынхаа ЗДТГ-тай хамтран бичил уурхай эрхлэгч бүх гишүүдийнхээ

хурлыг хийдэг. Энэ үеэр нөхөрлөлийн шинэчилсэн бүртгэлд гишүүдээ хамруулж, үнэмлэх олгон тухайн жилд ажиллах эрхийг нь олгодог байна.

**Туршлага:** Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Дууш мандал хайрхан холбоо” ТББ өөрийн гишүүд бичил уурхай эрхлэгчдээс бүрдсэн авран туслах баг байгуулж, сургалтанд хамруулж, дадлагажуулсан бөгөөд уг авран туслах баг сар бүр нөхөрлөлүүдэд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, тэдний олборлолт явуулж байгаа аманд үзлэг шалгалт хийж заншсан байна. Тус авран туслах баг нь 2010 онд улсын чанартай мэргэжлийн аврах багуудын дунд зохион байгуулагддаг тэмцээнд амжилттай оролцжээ. “Дууш мандал хайрхан холбоо” ТББ нь Түнхэл дэхь бичил уурхайчдын олборлолт явуулж буй газарт аюулгүй ажиллагааны дүрэм журам бүхий самбар байрлуулсан нь тэнд үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчдад өдөр бүр аюулгүй ажиллагааны дүрэм журмаа санаж, дагаж мөрдөхөд илүү дөхөмтэй ажил болжээ.



#### **14. Мандал сумын “Дууш мандал хайрхан холбоо” ТББ-ын дэргэдэх авран туслах баг болон Түнхэл дэхь олборлолтын газар.**

**Туршлага:** 2009-2010 онуудад Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Жаргалант сумын бичил уурхайчдын ТББ-ууд 10.1 га талбайд нөхөн сэргээлт хийсэн бол Сэлэнгэ аймгийн Мандал суманд бичил уурхайчид 180 суулгац тарьсан байна.

**Туршлага:** Сэлэнгэ, Баянхонгор, Төв аймгийн бичил уурхайчдын ТББ-ууд орон нутгийн цагдаа, байгаль орчин болон нийгмийн даатгалын хэлтэс, цэцэрлэг зэрэг газруудтай бичил уурхай эрхлэгчдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж

хэвшсэн байна. Тухайлбал цагдаагийн байгууллагатай нийгмийн хэв журам сахиулах, гадны иргэд талбай дээр нь ажиллахаас сэргийлэх, архины худалдааг таслан зогсоох чиглэлээр, бичил уурхайчдын хүүхдүүдийг зуны цагт олборлолтын талбайгаас хол байлгах, нүхэнд унахаас сэргийлэх, хүмүүжил төлөвшлийн арга хэмжээ явуулах, гэр цэцэрлэг ажиллуулах чиглэлээр сумын цэцэрлэгтэй гэрээ байгуулан ажилладаг байна. Эдгээр байгууллагуудтай гэрээ хийхдээ аливаа үйл ажиллагаа явуулах зардлын 50%-ийг ТББ, 50%-ийг тухайн байгууллагууд хариуцдаг байна. Эдгээр үйлчилгээг авахын тулд бичил уурхайчид өөрсдөө зохион байгуулалтанд орсон, ТББ-даа бүртгэлтэй байхыг шаарддаг ажээ.


**Сургамж:** Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын “Баян бөмбөгөр” ТББ 128 гишүүнтэй. Төслийн зүгээс болон ТББ-аас нийт 6 удаа явуулсан сургалтанд оролцогчдыг нэрсийн жагсаалтаас шүүгээд үзэхэд дээрхи 6 удаагийн сургалтанд 120 хүн биш. 20 хүн 6 удаа суусан байв. ТББ бүх гишүүдийн хурлаа хийхэд 20 хүн цуглардаг болсон. Энэ нь ТББ гишүүддээ чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй, ТББ-ын удирдлага хангалтгүй ажилласантай холбоотой.

**Сургамж:** “Байдрагийн хөгжил” ТББ санхүүгийн зарцуулалтаа гишүүддээ тайлагнаагүйгээс гишүүд нь цагдаад гомдол гаргаж, улмаар ажил хариуцсан хүн нь 3 сарын түрш хууль сахиулах байгууллагад шалгагдсан байна.

### 3. Бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ын ирээдүйн чиг хандлага

#### Олон улсын туршлага

Дэлхий даяар 2010 оны байдлаар 70 орчим оронд 100 сая гаруй хүмүүс бичил уурхайгаас аж амьдралаа залгуулж байгаа тооцоог “Бичил уурхайн олон улсын нийгэмлэг”-ээс гаргасан байдаг. Эдгээр улсуудад бичил уурхайчдын тоо 10 мянгаас давах үед бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд орж, үндэсний хэмжээнд өөрсдийг нь төлөөлөх толгой байгууллага байгуулдаг байна.



15. Бичил уурхайчид бүхий улс орнууд, бичил уурхайчдын тоо (CASM веб хуудас, 2011)

#### 13. Бичил уурхайчдын эрх ашгийг хамгаалах үндэсний хэмжээний байгууллага

Бичил уурхайчид цөөхүүлээ эрх ашгаа хамгаалж чадахгүй, мэдлэг, ур чадвар сул, санхүүгийн хувьд тогтворгүй, бичил уурхайн дэд салбарын дуу хоолойг олон нийтэд болон шийдвэр гаргагчид хүргэж чаддаггүй байдал нь өөрсдийн гэсэн байгууллагыг үндэсний хэмжээнд байгуулах шаардлагыг бий болгодог байна. Ихэнх орнуудад бичил уурхайчид дараах төрлийн байгууллагуудын доор нэгдэж үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Уул уурхайн үйлдвэрчний эвлэл
2. Үндэсний болон бүсийн холбоо, нийгэмлэгүүд
3. Уул уурхайн том компаниуд болон тэдгээрийн дэргэдэх зөвлөл, танхим
4. Төрийн бус байгууллага

Дээрх байгууллагууд нь бичил уурхайчдын нөхөрлөл болон орон нутгын төрийн бус байгууллагуудыг үндэсний хэмжээнд төлөөлж, эрх ашгийг нь хамгаалдаг байна. Тухайн улсын нийгмийн байгуулал, эрх зүйн тогтолцоо, олборлож буй ашигт малтмалын төрөл, зах зээлийн орчин зэргээсээ шалтгаалж дээрх 4 төрлийн байгууллагаас аль тохирох нь нийт бичил уурхайчдынхаа эрх ашгийг Засгийн газар, хувийн хэвшил, олон улсад төлөөлж ажилладаг. Африк, Өмнөд америкийн зарим улсууд мэдээллийн хувьд хаагдмал, бичил уурхайн хууль эрх зүйн орчин байхгүй, цэргийн болон дарангуйлалын засаглалтай байгаагаас болж уул уурхайн компанийн доор нэгдэх тохиолдол элбэг байдаг. Мөн өөрсдийн эрх ашгийг хамгаалсан байгууллага байгуулах нь хүндрэлтэй байдгаас тэр болгон ТББ юмуу Холбоо, Ассоциаци байгуулж чаддаггүй. Тиймээс урьд нь байгуулагдсан аль нэг байгууллага эсвэл үйлдвэрчний эвлэлийн доор нэгдэх тохиолдолууд элбэг байдаг.

Харин Монгол улс ардчилсан, парламентын засаглалтай, зах зээлийн эдийн засагтай байгаа нь бусад орнуудыг бодвол давуу тал бөгөөд бичил уурхайчид өөрсдийн удирдах байгууллагыг байгуулах боломж нээлттэй юм. Тиймээс бичил уурхайчдын ТББ-ууд болон бичил уурхайчид хоорондоо хэлэлцэж бүсийн хэмжээнд болон үндэстний хэмжээнд бүх бичил уурхайчдын эрх ашгийг хамгаалж, үйл ажиллагаа явуулах холбоо, нийгэмлэг байгуулах бүрэн боломжтой төдийгүй бодит хэрэгцээ шаардлага урган гарч ирж байна.


## **2. Шударга худалдаа, хариуцлагатай олборлолт (FTFM)**

1960-аад оноос дэлхий дахинаа “шударга худалдаа” (fair trade) хэмээх хөдөлгөөн өрнөж худалдааны шинэ санаачилга гарч ирснээр хөдөө аж ахуйн зарим бараа бүтээгдэхүүнүүд дээр уг шошгыг наах болж, хөгжингүй орны худалдан авагчид ийм шошго бүхий бүтээгдэхүүнийг түлхүү авах болсон байна. Зарим тохиолдолд уг бараа бүтээгдэхүүн нь ижил төрлийн бараа бүтээгдэхүүнээс арай илүү үнэтэй байдаг ч хүмүүс худалдаж авахдаа цааргалдаггүй.



#### 16. “Шударга худалдаа”-ны шошго бүхий гадил жимс

Энэ нь орон нутгийн орлого багатай иргэдийн гар дээрээс стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг шууд худалдаж авч, олон шат дамжилгагүйгээр хэрэглэгчдэд хүргэснээр тухайн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй иргэдэд илүү өндөр үнэ төлж, амьдарлыг нь сайжруулах боломж олгох болсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл, нэг ширхэг гадил жимсийг тухайн нутгийнхаа компанид худалдсанаас даруй нэг дахин илүү үнийг “Шударга худалдаа” олон улын байгууллага иргэдэд өгдөг нь орлого багатай иргэд амьжиргаагаа сайжруулах боломжийг илүү олгодог байна. Өндөр хөгжилтэй орны иргэд ч хөгжиж буй орны иргэдийн төлөө тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдаж авч зарим тохиолдолд илүү үнэ төлөхдөө баяртай байх болсон байна.



#### 17. Бичил уурхайчдын мөнгөн ус хэрэглэлгүйгээр хуулийн дагуу олборлосон алт FTFM-ын гол түүхий эд болдог

Үүнтэй адил алт, бриллиант зэрэг үнэт ашигт малтмал дээр мөн ийм худалдааны сүлжээ (FLO, ARM) байдаг бөгөөд энэхүү байгууллага нь орон нутгийн нөхөрлөл, төлөөллийнх нь байгууллагуудаас алтыг Лондонгийн хөрөнгийн биржийн үнийн 95%-тай тэнцэх үнээр шууд



худалдан авдаг байна. Түүнчлэн тухайн худалдаж авсан нийт алтны үнийн 10%-тай тэнцэх нэмэлт санхүүжилтийг уг нэгж байгууллага, нөхөрлөлийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдийн нийгмийн хангамжийг сайжруулах зорилгоор олгодог. Хэрэв уг алт олборлож буй нөхөрлөл байгууллага (Монголд бол ТББ нь нөхөрлөлүүдээ нэгтгэж уг байгууллагын шууд харилцах байгууллага болж болох талтай) нь химийн хорт бодис хэрэглэлгүйгээр алт олборлосон бол дээрх 10%-ийн санхүүжилт нь 15% болж өсөх юм. Хөгжингүй орны иргэд алтаар хийсэн үнэт эдлэл зэргийг илүүтэй худалдан авч, хөгжиж буй орны иргэдийн амьдралд хувь нэмрээ оруулдаг байна.

Цаашид Монголын бичил уурхай эрхлэгчид, ялангуяа алт олборлож буй иргэд зохион байгуулалтанд орж Монгол Улсын хууль дүрмийг ягштал баримталж ажиллаж чадвал энэхүү Fairtrade Labelling Organizations International (FLO) болон Alliance for Responsible Mining (ARM) байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг Монголд явуулах нөхцөл бүрдэх юм. Эндээс бичил уурхайчдын нөхөрлөл болон бичил уурхайчдын ТББ-ын идэвхитэй, үр дүнтэй үйл ажиллагааны ач холбогдол тодорхой харагдаж байна.